



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 05 сарын 17-ны
өдрийн 6814 дугаарт бүртгэв.

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах,
халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд
бүртгэх журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам"-ыг нэгдүгээр, "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын улсын бүртгэлийн гэрчилгээний загвар"-ыг хоёрдугаар, "Бодис бүртгүүлэх өргөдлийн маягт"-ыг гуравдугаар, "Бодисын хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны зааврын маягт"-ыг дөрөвдүгээр, "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх ажил үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын тайлан мэдээний маягт"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Энхтуяа)-д даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/143 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141240171

**АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ,
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Эрүүл мэндийн байгууллага, нийтийн үйлчилгээний газар, хүнсний үйлдвэр, цэцэрлэг, сургуульд хэрэглэх ариутгах, халдваргүйжүүлэх бодис (цаашид "бодис" гэх)-ыг Монгол Улсад бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, бүртгэлээс хасах харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн яамны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) нь бодисын бүртгэл, сунгалт, өөрчлөлт, бүртгэлээс хасах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 1.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь (цаашид "Ажлын алба" гэх) ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг хариуцан ажиллана.

Хоёр. Ажлын албаны үйл ажиллагаа

- 2.1. Ажлын алба нь ариутгах халдваргүйжүүлэх бодисыг бүртгэхэд орон тооны бус шинжээчийг ажиллуулж дүгнэлт гаргуулна.
- 2.2. Ажлын алба дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ:
 - 2.2.1. Бүртгүүлэгчээс ирүүлсэн цаасан болон цахим материалд анхдагч дүн шинжилгээ хийж, шинжээч томилон ажиллуулна. Материал дутуу ирүүлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн бол шаардлага хангаагүйд тооцож буцаах;
 - 2.2.2. Шинжээчийн дүгнэлтийг хүлээн авч, ажлын албаны хурлыг хуралдуулан шаардлага хангасан материалыг зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрийг үндэслэн гэрчилгээ олгох, мэдээний санд оруулах, холбогдох байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг хариуцах;
 - 2.2.3. Бодисын бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах талаарх саналыг Зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах;
 - 2.2.4. Тухайн жилд Монгол Улсад ашиглаж болох ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал халдваргүйжүүлэх бодисын жагсаалт, тоо хэмжээг нэгтгэн батлуулж, Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалд тусгуулан батлуулах;
 - 2.2.5. Шаардлагатай тохиолдолд ажлын алба нь үйлдвэрлэгчээс ирүүлсэн баримт бичгийн талаар тухайн улсын эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодруулга авах ба гарах зардлыг бүртгүүлэгч тал хариуцах;

2.2.6. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх үйлчилгээний бүртгэл, мэдээллийг энэхүү тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу үйлчилгээ эрхлэгч байгууллагаас авч, нэгтгэн, жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт хүргүүлэх

2.2.7. Бүртгэлийн баримт бичгийг архивлах үйл ажиллагааг зохион байгуулах;

Гурав. Бүртгэлд тавигдах ерөнхий шалгуур

3.1. Европын холбоо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ), Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага (FAO), Америкийн Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг (EPA)-аас сэрэмжлүүлсэн бодисын жагсаалтад ороогүй байх;

3.2. Олон улсын ISO:9001, ISO:14001 стандартын шаардлага хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байх;

3.3. Экспортлогч улсын үйлдвэрлэгч байгууллага эсвэл итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн байх;

3.4. Экспортлогч улсын үйлдвэрлэгч байгууллагын гарал үүслийн гэрчилгээ, бодисын чанарын гэрчилгээтэй байх;

3.5. Импортын бодис нь үйлдвэрлэгч орны зах зээлд гурваас доошгүй жил хэрэглэгдэж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй болохыг нь баталгаажуулсан баримт бичигтэй байх (баталгаат орчуулгын хамт хавсаргасан байх);

3.6. Бодисын үйлчлэх бодис, идэвх, найрлага, тун, тогтвортой байдал нь шинжлэх ухааны туршилт судалгаагаар тогтоогдсон байх;

3.7. Бүртгэлийн баримт бичиг нь Монгол, Англи, Орос хэлний аль нэг дээр байх бөгөөд бусад хэл дээрх баримт бичгүүдэд дээрх 3 хэлний аль нэг дээр орчуулсан байх (баталгаат орчуулгыг хавсаргасан байх);

3.8. Бодисыг хэрэглэх заавар Монгол хэл дээр байх бөгөөд Хор аюулын лавлах мэдээллийн хуудсыг хавсаргасан байх;

3.9. Бүртгүүлэх бодисын үйлчлэл, чанар, аюулгүй байдал нь шинжээчийн дүгнэлт, судалгааны дүнгээр баталгаажсан байх;

Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа

4.1. Бүртгүүлэгч байгууллага нь бодисыг бүртгүүлэх тухай хүсэлт, бодистой холбоотой шаардлагатай баримт бичгийг цахим болон цаасаар Ажлын албанд ирүүлнэ.

4.2. Улсын бүртгэлд дараах бодисыг бүртгэнэ:

4.2.1. Эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэг, бусад үйлдвэр үйлчилгээний газруудад болон халдварт өвчний голомтын халдваргүйжүүлэлтийн үед айл өрхөд бүх төрлийн гадаргуугийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэх бодисууд;

4.2.2. Эмнэлгийн багаж, тоног, төхөөрөмж, хэрэгслийг бүх түвшинд ариутгах, халдваргүйжүүлэх бодисууд;

4.2.3. 70%-с дээш агууламжтай спиртэн суурьтай болон гар халдваргүйжүүлэгч бусад бодисууд;

4.2.4. Мэс заслын талбай, арьс салст халдваргүйжүүлэгч бодисууд;

4.3. Бүртгэлийн үйл ажиллагаа дараах үе шаттайгаар, дор дурдсан хугацаанд хэрэгжинэ:

Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
Бүртгэлийн баримт бичигт анхдагч дүн шинжилгээ хийх	Бүртгэлийн баримт бичгийг бүрэн хүлээж авснаас хойш ажлын 5 хоногт	Ажлын алба
Бүртгэлийн нэхэмжлэх, хураамж, барагдуулах төлбөр	Анхдагч дүн шинжилгээ хийснээс хойш ажлын 5 хоног дотор	Ажлын алба, бүртгүүлэгч
Шинжээчийн гаргуулах дүгнэлт	Шинжээчид материал өгснөөс хойш Ажлын 15 хоногийн дотор	Ажлын алба, шинжээчид
Шаардлага хангасан бодисыг бүртгүүлэх саналыг Зөвлөлд хүргүүлж, шийдвэр гаргуулах	Ажлын албаны хурлын тэмдэглэл эцэслэн гарснаас хойш ажлын 5 хоногт	Ажлын алба, зөвлөл
Хурлаас түдгэлзүүлж, хойшлуулсан тохиолдолд дахин хэлэлцэх асуудлыг зохион байгуулах	Зөвлөлийн шийдвэр, нэмж тодруулах зүйл бүрэн бүрдүүлэн ирүүлснээс хойш 20 хоногийн дотор	Ажлын алба, Бүртгүүлэгч байгууллага
Хурлын тэмдэглэл бичиж, албажуулах	Ажлын 5 хоног дотор	Ажлын алба
Улсын бүртгэлийн гэрчилгээ бичиж, олгох	Хурлын тэмдэглэл, шийдвэрийг баталгаажуулснаас хойш ажлын 5 хоногт	Ажлын алба, зөвлөл
"Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын жагсаалт, тэдгээрийн ашиглалтын хэмжээ"-г шинэчлэн батлуулах	Жил бүрийн 2 дугаар сард	Ажлын алба, зөвлөл
Мэдээллийн санг 1 удаа байгуулж, бүртгүүлсэн бодисыг мэдээллийн санд тухай бүр оруулж, мэдээллийн сангийн баяжилтыг хийж, үйл	Жил бүрийн 12 сард	Ажлын алба

ажиллагааны байдлыг хангах	тогтвортой	
-------------------------------	------------	--

4.4. Бодисыг нэр, үйлдвэрлэгч, улс, химийн бодисын үйлчилгээний олон улсын (CAS)-ын дугаар, хэлбэр, концентраци, савлалтын хэмжээ, хэрэглэх зориулалт тус бүрээр нь дугаар олгож улсын бүртгэлд бүртгэнэ.

4.5. Ажлын алба нь бодис бүртгүүлэх асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын шийдвэрээр бодисыг 3 жилийн хугацаатай бүртгэж гэрчилгээ олгоно.

Тав. Бодис бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

5.1. Импортын бодисыг бүртгүүлэгч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

5.1.1. Бодис бүртгүүлэх байгууллагын албан хүсэлт, хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт, зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;

5.1.2. Бодис бүртгүүлэх байгууллага, аж ахуйн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь (3 дугаар хавсралтын дагуу);

5.1.3. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

5.1.4. Үйлдвэрлэгч байгууллагын танилцуулга, орчуулгын хамт (цаасан болон цахим хэлбэрээр);

5.1.5. Үйлдвэрлэгчийн чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ (ISO:13485)-ний хуулбар;

5.1.6. Тухайн бодисын гарал үүслийн гэрчилгээ, чанарын гэрчилгээ дагалдах сертификат, баталгаат орчуулгын хамт;

5.1.7. Тухайн бодисын нэршил, олон улсын бүртгэлийн дугаар (CAS), найрлага шинж чанар, болзошгүй эрсдэл, ашиглах тун хэмжээ, тээвэрлэх, хадгалах, устгах заавар, аргачлал зэрэг мэдээллийг агуулсан хор аюулын лавлах мэдээлэл /MSDS, Datasheet/

5.1.8. Тухайн бодисын үйлдвэрлэгчээс гаргасан хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны заавар /4 дүгээр хавсралтын дагуу/;

5.1.9. Бодисыг хэрэглэх хэрэглэгчдэд зориулсан заавар, баталгаат орчуулгын хамт;

5.1.10. Бүртгүүлэгчийн үйлдвэрлэгч байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээ;

5.1.11. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хуудас;

5.1.12. Тухайн бодисын үйлдвэрлэгч улсын үйлчилгээ, үр дүнг баталсан мэргэжлийн байгууллагын хийсэн сорилт туршилт судалгааны дүн;

5.1.13. Анхдагч болон хоёрдогч савлагааны зураг, загвар дээж;

5.2. Үндэсний үйлдвэрийн бодисыг бүртгүүлэгч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

5.2.1. Бодис бүртгүүлэх байгууллагын албан хүсэлт, хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт, зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;

5.2.2. Бодис бүртгүүлэх байгууллага, аж ахуйн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь (3 дугаар хавсралтын дагуу), бодис бүртгүүлэх байгууллагын албан хүсэлт;

5.2.3. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

5.2.4. Эрх бүхий байгууллагын олгосон оюуны өмчийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

5.2.5. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд /шинээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 2 цувралд/ хийсэн шинжилгээний дүн;

5.2.6. Бодист тавигдах ерөнхий шаардлагын стандарт буюу техникийн нөхцөлийг тодорхойлон баталсан стандарт, тохирлын гэрчилгээ;

5.2.7. Тухайн бодист хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний сорилтын дүн;

5.2.8. Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үүсгэх нөлөөний тухай судалгааны үр дүн ба илэрсэн гаж нөлөөний судалгааны дүн;

5.2.9. Тухайн бодисын үйлчилгээ, үр дүнг баталсан мэргэжлийн байгууллагын хийсэн туршилт судалгааны дүн;

5.2.10. Хэрэглэгчдэд зориулсан хэрэглэх найруулах заавар;

5.2.11. Тухайн бодисын нэршил, олон улсын бүртгэлийн дугаар (CAS), найрлага шинж чанар, болзошгүй эрсдэл, ашиглах тун хэмжээ, тээвэрлэх, хадгалах, устгах заавар, аргачлал /MSDS, Datasheet/;

5.2.12. Тухайн бодисын үйлдвэрлэгчийн гаргасан хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны заавар /5 дугаар хавсралтын дагуу/;

5.2.13. Үйлдвэрлэгчийн гаргасан тухайн бодисын шинжилгээний аргачлал;

5.2.14. Анхдагч болон хоёрдогч савлагааны зураг;

Зургаа. Бүртгэлийн хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох

6.1. Тухайн бодисыг анх бүртгүүлсэн байгууллага бүртгэлийн өөрчлөлт, хугацаа сунгуулахтай холбоотой баримт бичиг, албан хүсэлтийг ажлын албанд ирүүлнэ.

6.2. Бүртгүүлэгч бүртгэлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаргана.

6.3. Бодисын хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ: Бодисын бүртгэлийн гэрчилгээг 3 жилийн хугацаатайгаар сунгана.

6.3.1. Бүртгэлийн хугацааг сунгуулах тухай албан хүсэлт;

6.3.2. Эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн бодисын бүртгэлийн хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь (3 дугаар хавсралтын дагуу);

6.3.3. Хугацаа дуусах бүртгэлийн гэрчилгээний эх хувь;

6.3.4. Бодисын хор аюулгүйн лавлах мэдээллийн хуудас;

6.3.5. Бодисыг хэрэглэх аюулгүй ажиллагааны заавар;

6.3.6. Анхдагч болон хоёрдогч савлагааны загвар зураг;

6.4. Ажлын алба нь бүтээгдэхүүний бүртгэлийн хугацаа сунгахтай холбоотойгоор тухайн бодисын талаар хэрэглээний явцад хордлого гарсан эсэхийг химийн хордлогын тандалт бүртгэл мэдээллийн сангаас шалгаж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газар, зар сурталчилгаа, хэрэглээний талаарх зөрчлийн талаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас холбогдох санал, дүгнэлтийг авч зөвлөлд танилцуулна.

6.5. Бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ:

6.5.1. Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;

6.5.2. Эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах өргөдлийн эх хувь (3 дугаар хавсралтын дагуу);

6.5.3. Өөрчлөлттэй холбоотой дэлгэрэнгүй тайлбар, холбогдох баримт бичиг (анхдагч ба хоёрдогч савлалт өөрчлөгдсөн бол хуучин болон шинэ загварын өнгөт, дэлгэмэл зургийг харьцуулан хавсаргах, эцсийн бүтээгдэхүүн, үндсэн үйлчлэгч бодисын шинжилгээний аргачлалд өөрчлөлт орсон бол ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг хавсаргах);

6.5.4. Худалдааны нэр болон бодисын найрлагад өөрчлөлт орсон тохиолдолд бүртгэлийн бүрэн баримт бичгийг шинээр бүрдүүлнэ.

6.6. Дараах тохиолдолд бодисын бүртгэлийг хүчингүй болгоно:

6.6.1 Гарал үүслийн улсын бүртгэлээс хасагдсан болон хэрэглэхээ больсон бодисууд;

6.6.2. Бүртгүүлэгч болон үйлдвэрлэгчээс бүртгэлийг хүчингүй болгох албан хүсэлт ирүүлсэн;

6.6.3. Тандалт судалгаагаар тухайн бүтээгдэхүүн чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй болохыг итгэмжлэгдсэн эсхүл лавлагаа лабораторийн шинжилгээ болон бусад баримт бичиг, судалгааны дүн, мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон;

6.6.4. Хуурамч баримт бичиг бүрдүүлэн бүртгүүлэх, бүртгэлийг өөрчлөх, хугацаа сунгуулахтай холбоотой шийдвэр гаргуулсан болохыг тогтоосон шинжээч, хууль, хяналтын байгууллагын дүгнэлт;

6.6.5. Тухайн бүтээгдэхүүний чанар, идэвх, аюулгүй байдлын талаар эрүүл мэндийн байгууллага, иргэдээс ирсэн гомдлын мөрөөр хууль, хяналтын байгууллага шалган шийдвэрлэсний дагуу бүртгэлээс хасах санал ирүүлсэн;

6.6.6. Бүтээгдэхүүний чанар болон ноцтой гаж нөлөөний улмаас хүний амь эрсэдсэн, удаан хугацаагаар эмчлүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан нь холбогдох хууль, хяналтын байгууллагын шалгалтаар нотлогдсон;

6.6.7. ДЭМБ болон тухайн улсын эрх бүхий зохицуулалтын эрх бүхий байгууллагаас тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэхийг хориглосон тухай гаргасан шийдвэр;

6.7. Бүртгэлээс хассан болон зах зээлээс эргүүлэн татах шийдвэр гарсан тохиолдолд Зөвлөлийн хурлын тэмдэглэл гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор холбогдох хууль, хяналтын байгууллагад мэдээлж, мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

6.8. Бүтээгдэхүүний бүртгэлийг сунгуулах хүсэлтийг энэхүү журмын 6.2-т заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд бүртгэлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн бүртгэлгүйд тооцож, ажлын алба бүртгэлээс хасагдсан тэмдэглэгээг мэдээний санд хийнэ.

Долоо. Үнэлгээний мэдээллийн сан, хянан магадлагаа

7.1. Үнэлгээний мэдээллийг нээлттэй болгох зорилгоор Ажлын алба бүртгэлийн мэдээллийн санг байгуулна.

7.2. Мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулна:

7.2.1. Бүртгэлтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд

7.2.2. Бүртгэлийн тайлангийн товч танилцуулга

7.2.3. Хянан магадалгааны дүгнэлт, авсан арга хэмжээ, биелэлт

7.2.4. Химийн аюулгүй байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө

7.2.5. Монгол Улсад ашиглаж болох ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт

- 7.3. Зөвлөлөөр батлагдсан бүртгэлийн эх тайланг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын архивд хадгална.
- 7.4. Бүртгэлийн баримт бичиг, шинжээчийн дүгнэлт үнэн зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг хянан магадалгаа гэх бөгөөд жил бүрийн төлөвлөгөө, хянан магадлагаа хийх ажлын хэсгийг мэргэжлийн хүмүүсийг оролцуулан зөвлөлөөс батлан гаргана.
- 7.5. Хянан магадлагаа хийх ажлын удирдамжид хянан магадлагаа хийх хугацаа, ажлын цар хүрээ, аргачлал зэрэг асуудлыг тусгаж, зөвлөлийн дарга батална.
- 7.6. Хянан магадлагааны дүгнэлтийг холбогдох талуудыг оролцуулан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
04 сарын 20 өдрийн тушаалын
2 дугаар хавсралт

**АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР**

Соёмбо

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
MINISTRY OF HEALTH OF MONGOLIA

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
INSECTICIDE, RODENTICIDE, ANTICCEPTIC, DISINFECTANT REGISTRATION
CERTIFICATE

№

Бүртгэлийн дугаар
Registration number

Бодисын олон улсын нэршил
International name of the chemical

Бодисын худалдааны нэршил
Trade name of the chemical

Үйлчлэгч бодисын нэр, агууламж
Active ingredient and concentration of chemical

CAS-ын дугаар
CAS number


Бодисын хэлбэр, савлалтын хэмжээ
Chemicals form, package dosage

Хэрэглэх зориулалт
Intended use

Үйлдвэрлэгчийн нэр
Manufacturer name

Гарал үүслийн улс
Country of origin

Бүртгэл ньонысарын өдөр хүртэл хүчинтэй.
Registration valid until _____(day) _____(month) _____(year)
Дэд сайд _____(гарын үсэг) _____(нэр) (Тамга)
State Secretary of the MoH



БОДИС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжнийг тэмдэглэ)

- Шинээр бүртгүүлэх
- Бүртгэлд өөрчлөлт оруулах
- Хугацаа сунгуулах

Өргөдлийн 1-р хэсгээс бусдыг Англи хэл дээр зөвхөн үйлдвэрлэгч бөглөнө (To be filled in English by manufacturer only except Part I)

I ХЭСЭГ. PART I	ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ. Өргөдөл гаргагч нь тухайн үйлдвэрийг Монголд төлөөлөх хууль ёсны эрхтэй төлөөлөгчийн газар эсхүл Монгол Улсын химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөлтэй байгууллага байна. INFORMATION ABOUT THE APPLICANT. The applicant is a representative office that has the legal right to represent the manufactory in Mongolia or an organization that has a special license of Mongolia to export, import, transport across the border, manufacture, sell, or use toxic or dangerous chemical substances
Байгууллагын нэр Name of organization	
Байгууллагын хаяг Site address	
Шуудангийн хаяг Postal address	
Утасны дугаар Telephone number	
Факсын дугаар Fax number	
Е-мэйл хаяг E-mail address	
Харилцах хүн, утасны дугаар Contact person, telephone number	
II ХЭСЭГ. PART II	ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ MANUFACTURER INFORMATION
Үйлдвэрлэгчийн нэр Name of manufacturer	
Үйлдвэрлэгчийн хаяг Manufacturing site address	
Гарал үүслийн улс Country of origin	

Утасны дугаар Telephone number			
Факсын дугаар Fax number			
Веб хаяг Web address			
Харилцах хүн Contact person			
Е-мэйл хаяг E-mail address			
III ХЭСЭГ. PART III	АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ INFORMATION ON HOUSEHOLD PEST CONTROL, ANTISEPTICS AND DISINFECTANTS		
Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын олон улсын нэр International name of the chemical			
Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын худалдааны нэр Trade name of the chemical			
Үйлчлэгч бодисын нэр, хэмжээ Name and strength of active ingredients			
Нэр Name	Агууламж Strength	Нэр Name	Агууламж Strength
1.		4.	
2.		5.	
3.		6.	
Туслах бодисын нэр тун хэмжээ Name and strength of inactive ingredients			
Нэр Name	Агууламж Strength	Нэр Name	Агууламж Strength
1.		5.	
2.		6.	
3.		7.	
4.		8.	
Бүртгэлийн дугаар Registration number			
CAS-ын дугаар (пестицид) CAS number (pesticide)			
Химийн томьёо Formula of chemical			
Хадгалах нөхцөл Storage condition			
Хүчинтэй хугацаа Shelf life			

Бодисын хэлбэр Chemicals form, package dosage	
Савлалтын хэмжээ (нэгж ба бөөнөөр савласан) Packing size (unit and bulk package)	
Хэрэглэх зориулалт Intended use	
Өртөг шингэсэн бөөний үнэ Wholesale Price	
IV ХЭСЭГ. PART IV	БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ REGISTRATION INFORMATION
Үйлдвэрлэгч улсад бүртгэсэн дугаар, огноо Registration number and date in country of origin	(dd/mm/yy)
Тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг улсын тоо, нэр Number and name of countries, this product was used	

1. Бүртгэлийн өргөдөл болон.....хуудас бүхий бүртгэлийн баримт бичгийн үнэн зөв байдлыг бүртгүүлэгч байгууллага бүрэн хариуцна.

1.1 Баримт бичгийг хүлээлгэн өгсөн:

.....овогтой.....(бүртгүүлэгч байгууллагын мэргэжилтэн)

.....гарын үсэг.....огноо.....

1.2 Зөвшөөрсөн:

.....овогтой (Дарга/Захирал)

.....гарын үсэг.....огноо.....

Өргөдлийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын

Эмийн бүртгэлийн хэлтэст ирүүлнэ.

Хаяг: UBH CENTER, Энхтайвангийн өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 14210

Улаанбаатар, Монгол Улс

Утас:

Мэйл: eehhgz@moh.mn

1. Applicant is fully responsible that the provided information in the application and registration dossier withpages is true and correct.

3.1. Submitted by:

.....surname.....name (responsible person of the company)

.....signature.....date.....

3.2. Accepted by:

.....surname.....name (director of the company)

.....signature.....date.....

The application should be submitted to:

Medicines Registration division

Medicine, Medical devices regulatory agency

Address: UBH CENTER, Peace Avenue, Sukhbaatar district, 1st khoroo 14210 Ulaanbaatar, Mongolia

Phone:

Mail: eehhgz@moh.mn

БОДИСЫН ХЭРЭГЛЭХ АРГА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВРЫН МАЯГТ

1	Бодисын худалдааны нэр	
2	Олон улсын ангилал, CAS	
3	Химийн найрлага, гарал ангилал	
4	Идэвхт үйлчлэгч бодисын нэр, хувь концентрат	
5	Химийн томьёо	
6	Савлалт, жин	
7	Хорын зэрэг	
8	Үйлдвэрлэгч улс	
9	Үйлдвэрлэгч байгууллага	
10	Хадгалах нөхцөл	
11	Хэрэглэх заалт	
12	Хэрэглэх найруулах заавар	
13	Ашиглах багаж	
14	Хориглох заалт	
15	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, авах арга хэмжээ	
16	Найруулсан ажлын уусмалыг хадгалах хугацаа, нөхцөл	
17	Тээвэрлэх үеийн шаардлага	
18	Устгал	

Жижиглэнгээр худалдах бол иргэдэд зориулсан санамжийг хавсаргана.

.....(аймаг, дүүрэг) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах,
халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхэлж буй (нэгж)-ийн
..... оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

20... оны ... сарын ... өдөр

Д/д	Объект		Үйлчилгээ		Үйлчилгээ хийсэн нийт талбай	Тайлбар
	Нэр	Тоо	Төрөл	Тоо		
1	Үйлдвэр		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
2	Эмнэлэг		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
3	Хүнс, худалдаа		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
5	Хүүхдийн байгууллага		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
8	Ил задгай талбай		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
9	Төвлөрсөн хогийн цэг		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
10	Дулааны шугам		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
11	Бусад		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
12	Нийт		Халдваргүйжүүлэлт			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			

Тайлан гаргасан: ----- / /

Хянасан: ----- / /

.....(аймаг, дүүрэг) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах,
 халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхэлж буй..... (нэгж)-ийн
оны хүний нөөцийн тайлан

20... оны ... сарын .. өдөр

№	Үндсэн мэргэжил	Эрхэлж буй албан тушаал		Сургууль төгссөн он	Халдвар судлалын чиглэлээр мэргэжил эзэмшсэн он	Тухайн онд шинээр ажилд орсон хүн
		Үндсэн орон тоогоор	Гэрээгээр			
1.	Тархвар судлаач эмч					
2.	Хүний их эмч					
3.	Химич					
4.	Биологич					
5.	Сувилагч					
6.	Ариутгагч					
7.	Бусад дээд мэргэжилтэн					
8.	Бусад дунд мэргэжилтэн					
9.	Мэргэжилгүй НИЙТ					

**АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН МЭДЭЭНИЙ МАЯГТ**

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
08 сарын 20 өдрийн 47 тушаалын
5 дугаар хавсралт

Маяг А

**АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН
БҮРТГЭЛ**

20.. оны ... сарын ... өдөр

д/д	Он сар өдөр		Үйлчлүүлэгч байгууллага				Үйлчилгээ			Хэрэглэсэн химийн бодис		Нэгжид хийсэн тандалт		Тайлбар
	Нэр	Хаяг, утас	Төрөл	Талбай (м ²)	Цаг хугацаа	Нэр	Хэмжээ	өмнө	ойно					

Тайлбар: Тухайн байгууллагад хөтлөгдөнө.

7

